# НИСЭХИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН КАТАЛОГ



МОНГОЛ УЛС
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
CIVIL AVIATION AUTHORITY OF MONGOLIA

ИРГЭНИЙ НИСЭХИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭ
CERTIFICATE OF CIVIL AVIATION TRAINING ORGANISATION

№ MCAA.141.05

| | |
|---|---|
| Байгууллагын нэр:<br>*Name of Organisation* | ИНЕГ-ын Сургалтын төв<br>*Training Center of CAA of Mongolia* |
| Бизнес хаяг:<br>*Whose business address* | Монгол улс,17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа<br>*Buyant-Ukhaa, 10th khoroo, Khan-Uul district, Ulaanbaatar 17120, Mongolia* |

Дээр дурдсан байгууллага нь Монголын Иргэний нисэхийн дүрэм ИНД-141-ийн шаардлагуудыг хангасан ба тус гэрчилгээний салшгүй нэг хэсэг болох "Үйл ажиллагааны тодорхойлолт"-д заагдсан сургалтыг явуулах эрхтэй.
*It is hereby certified that the above mentioned organization complies with the requirements of the Mongolian Civil Aviation Regulations Part 141, and is adequate to conduct trainings specified in the attached Operations Specifications which is an integral part of this Certificate.*

Энэхүү гэрчилгээг бусдад шилжүүлж үл болно. Түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгосноос бусад тохиолдолд энэхүү гэрчилгээ нь доор заагдсан хугацаа хүртэл хүчинтэй.
*This certificate is not transferable and shall remain in force until specified date of expiry, unless sooner suspended or revoked.*

ОЛГОСОН / *ISSUED BY:*

Гарын үсэг: ........................ Олгосон огноо: 2016.05.01
*Signature* *Date of Issue* 01.May.2016

Олгосон албан тушаалтан: Ч.Батсайхан / Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн дарга /
*Position* *Batsaikhan.Ch / Director of personnel licensing /*

Энэхүү гэрчилгээ нь 2021.05.01 хүртэл хүчинтэй.
*This certificate in effect until* 01.May.2021

# 2019

# ЕРӨНХИЙ СУРГАЛТУУД



## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 өдөр /24 цаг/
Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн салбарын шинэ ажилтнуудад зориулан иргэний нисэхийн үйл ажиллагааны талаар анхан шатны ойлголт өгөхөд оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Иргэний нисэхийн салбарын шинэ ажилтнууд

## ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ТАЛААРХ ОНОЛЫН СУУРЬ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 6 өдөр /46 цаг/
Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн салбарын ажилтнуудад хүний хүчин зүйлийн талаарх ерөнхий суурь ойлголтыг олгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Иргэний нисэхийн салбарын ажилтнуудыг хамруулна.

## КОМПЬЮТЕРИЙН АНХАН ШАТНЫ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 7 өдөр /56 цаг/
Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн ажилтнуудын компьютерийн мэдлэгийг дээшлүүлж, компьютер тоног төхөөрөмжийг зөв хэрэглэж сурах, өргөн хэрэглээний програмтай ажиллах, интернет болон дотоод сүлжээг бүрэн ашиглаж сурахад энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## КОМПЬЮТЕРИЙН ДАВТАН СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 5 өдөр /40 цаг/
Сургалтын зорилго:

Нисэхийн сургалтын төвд компьютерийн анхан шатны сургалтад хамрагдсан хүмүүст зориулан эх бэлтгэлийн болон зураг засварлах мэргэжлийн програмтай ажиллах чадвар эзэмшүүлэхээс гадна, компьютер тоног төхөөрөмжид зохих тохиргоо, үйлчилгээ хийх чадварыг эзэмшүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## АЮУЛТАЙ АЧААНЫ ОНОЛЫН СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 өдөр /24 цаг/

Сургалтын зорилго:

Суралцагчдад зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвүүдийн дагуу үндсэн мэдлэг олгож, аюултай ачааг зөв таних, зөв харьцаж ажиллах, аюултай ачааг нуугдмал хэлбэрээр агаарын хөлөгт тээвэрлэгдэхээс урьдчилан сэргийлэх болон аюултай ачаатай холбоотой осол зөрчлийн үед анхан шатны арга хэмжээ авах чадвартай болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН АЮУЛТАЙ АЧААНЫ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 өдөр /24 цаг/

Сургалтын зорилго:

Аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөлгүй агаарын тээвэрлэгчийн ажилтнуудад ИАТА аюултай ачааны журамд заасан зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвүүдийн дагуу үндсэн ойлголт, аюултай ачааны хязгаарлалт, зорчигч болон агаарын хөлгийн гишүүдэд авч явах зөвшөөрөлтэй аюултай ачааны жагсаалт, савлагаа, тэмдэглэгээ, шошго болон бичиг баримт, аюултай ачааг зөв таних, харьцаж ажиллах, ачааг нуугдмал хэлбэрээр агаарын хөлөгт ачигдахаас урьдчилан сэргийлэх, аюултай ачаатай холбоотой осол зөрчлийн үед анхан шатны арга хэмжээ авах тухай мэдлэгтэй болгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд

- Иргэний нисэхийн салбарын ажилтнууд

## ЕРӨНХИЙ АНГЛИ ХЭЛНИЙ СУУРЬТАЙ АНХАН ШАТНЫ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 5 хоног /40 цаг/

Сургалтын зорилго:

Англи хэлний анхан шатны түвшинд суралцагчдад англи хэлний дүрмийн үндсэн мэдлэг олгож, өдөр тутмын энгийн харилцаанд санаа бодлоо товч байдлаар илэрхийлж сургах мэдлэг дадал олгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Иргэний нисэхийн салбарын ажилтнууд

## ЕРӨНХИЙ АНГЛИ ХЭЛНИЙ ДУНДЫН ДООД ТҮВШНИЙ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 5 хоног /40 цаг/

Сургалтын зорилго:

Энэхүү сургалтын гол зорилго нь ерөнхий Англи хэлийг өдөр тутмын энгийн харилцаандаа болон ажлын орчинд харилцах чадварыг нь дээшлүүлэх, Англи хэлний хэлзүй, үгсийн сан, яриа сонсгол, уншиж ойлгох чадвар, дүрмийн мэдлэгийн дунд шат хүртэлх суурь мэдлэг олгож, суралцагчийн дунд шатны идэвхтэй хэрэглээний үг хэллэгийн нөөц эзэмшүүлж, тэдгээрийг ашиглан харилцаанд орж сургахад оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## ЕРӨНХИЙ АНГЛИ ХЭЛНИЙ ДУНД ТҮВШНИЙ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 5 хоног /40 цаг/

Сургалтын зорилго:

Энэхүү сургалтын гол зорилго нь ерөнхий Англи хэлийг өдөр тутмын энгийн болон албан харилцаанд харилцах чадварыг нь дээшлүүлэх, Англи хэлний хэлзүй, үгсийн сан, яриа сонсгол, уншиж ойлгох чадвар, дүрмийн мэдлэгийн дунд шатны мэдлэгийг ахиулж, суралцагчийн дунд шатны идэвхтэй хэрэглээний үг хэллэгийн нөөц эзэмшүүлж, тэдгээрийг ашиглан аман болон бичгийн харилцааг сургахад оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ХУУЛЬ, ДҮРМИЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 1 өдөр /8 цаг/

Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн ажилтнуудад иргэний нисэхийн холбогдолтой олон улсын гэрээ конвенц, хууль, дүрэм, олон улсын стандарт, зөвлөмжүүд, иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үүрэг хариуцлага, осол зөрчлийн талаар ерөнхий ойлголт, мэдлэгийг шинээр олгох, баталгаажуулах, сэргээх зорилготой.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 2 өдөр /16 цаг/

Сургалтын зорилго:

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг ИНЕГ-т хэрэгжүүлэх, агаарын тээвэрлэгч ба үйлчилгээний байгууллагад аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд уг сургалтын зорилго оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилтнууд

## ЭРСДЭЛИЙГ УРЬДЧИЛАН МЭДЭЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛГҮЙ АЖИЛЛАХ ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 2 өдөр /16 цаг/

Сургалтын зорилго:

ИНЕГ, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал болон орон нутгийн нисэх буудлуудын ажилтнуудын хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх суурь мэдлэгийг бататгаж, ажлынбайрныаюулыгтанинмэдэх, эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх чадвар олгоход оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Нийт ажилчид

## НИСЛЭГИЙН ЦАГ УУР

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 5 долоо хоног /40 цаг/

Сургалтын зорилго

Суралцагчид нислэгийн цаг уурын ерөнхий мэдлэг эзэмшиж, дадлагатай болсноор ажилдаа ашиглаж чаддаг болно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд

- Агаарын тээврийн байгууллагуудын ажилтнууд